



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/108

Батширээт сум

Хагас жилийн мал
тооллого явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн 7.1.в дэх заалт, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/319 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрт хагас жилийн мал тооллогын ажлыг 2025 оны 06 дугаар сарын 04-нөөс 2025 оны 06 дугаар сарын 10-ны хооронд зохион байгуулсугай.

2. 2025 оны "Хагас жилийн мал тооллого"-ын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Төрмөнх

Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Ч.Сансартуяа

Статистик хариуцсан
мэргэжилтэн

Гишүүдэд:

Л. Мөнхчулуун

Хурх багийн Засаг дарга

В. Чулуун

Барх багийн Засаг дарга

Д. Хонгорзул

Онон багийн Засаг дарга

Б.Бадамгарав

Норовлин багийн Засаг дарга


Ж.Ундрах

Мал эмнэлгийн Улсын байцаагч

3. Хагас жилийн мал тооллогын ажлыг хуулийн хүрээнд хугацаанд нь чанартай зохион байгуулж, ажлын хэсэгт арга зүйн зөвлөмж өгч, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч бөгөөд ажлын хэсгийн ахлагч (Б.Төрмөнх)-д үүрэг болгосугай.

4. Хагас жилийн мал тооллогыг засаг захиргааны нэгжид зохион байгуулахад шаардлагатай заавар зөвлөмжийг өгч, тооллогыг нэг зэрэг хугацаанд эхлүүлж чанартай зохион байгуулахад хяналт тавьж тооллогын шивэлт эцэслэн боловсруулж аймгийн хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 10-нд мэдээлэхийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Ч.Сансартуяа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



БАЛТАНГЭРЭЛ

23250115